



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОВД АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ
АУДИТЫН КОД: ХОА-2024/03-20-НА-НА

Ховд хот
2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг
Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Бадрал Цахим хаяг: Badralts@audit.gov.mn
Аудитор: Д.Мөнхтулга munkhtulgad@audit.gov.mn
Аудитор: А.Нарандэлгэр narandelgera@audit.gov.mn
Аудитор: Н.Ариунтуяа ariuntuyan@audit.gov.mn



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	2
ХҮСНЭГТ БОЛОН ГРАФИКИЙН ТОВЬЁГ	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
БҮЛЭГ 1. ОРЛОГЫГ 129.7 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	6
Татварын орлогыг 109.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.....	6
Татварын бус орлогыг төлөвлөлтийг оновчтой болгон төлөвлөх шаардлагатай байна	7
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДЭХ АЖЛУУДЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	9
Урсгал зардлыг тооцоо судалгаанд үндэслэн нэмэгдүүлэн төлөвлөсөн байна	9
Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй, ерөнхий нэрээр тусгасан төсөл арга хэмжээнүүд нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахгүй байна.....	10
БҮЛЭГ 3. ОНХС-ГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ, ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭН АВЛАГЫГ БУУРУУЛСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	12
Төсвийн төсөлд 18 хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээг төлөвлөжээ.....	12
ЗӨВЛӨМЖ:.....	15
ХАВСРАЛТУУД	16

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
БХС	Байгаль хамгаалах сан
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮК	Төрийн үйлчилгээний компани
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Зам, шугам сүлжээний газрын төлбөрийн судалгаа	16
Хавсралт 2	Хог хаягдлын хураамжийн судалгаа	17
Хавсралт 3	Үенч-бодонч-булган голын сав газрын захиргааны 2024 онд ус ашиглуулах дүгнэлтийн судалгаа	17
Хавсралт 4	Ус ашиглагч тээврийн компаниудын судалгаа	18
Хавсралт 5	Зураг төсөв, урьдчилан тооцоолол байхгүй төсөл арга хэмжээний судалгаа /сая.төг/	20
Хавсралт 6	Урд оны төсвөөр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт /сая.төг/	21

ХҮСНЭГТ БОЛОН ГРАФИКИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ЗДТГ-ын эзэмшлийн байрны судалгаа	7
Хүснэгт 2	Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний бүтэц орон тоо	9
Хүснэгт 3	Төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээний жагсаалт	10
Хүснэгт 4	Ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй ТАХ-ний жагсаалт	11
Хүснэгт 5	Төсөв зөрүүтэй ТАХ-ний жагсаалт	11
Хүснэгт 6	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч ААНБ-уудын судалгаа	12
Хүснэгт 7	ТЕЗ-ийн 2023 оны авлагын үлдэгдлийн судалгаа	13
Хүснэгт 8	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт	14

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” заалт Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Ховд аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд: ➤ Төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэх, ➤ Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх, ➤ Төсвийн төсөлд төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх,
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001-д нийцүүлсэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”-ын стандарт арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар “Төрийн аудит байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дугаар “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав.
Аудитын хамарсан хүрээ	Ховд аймгийн Засаг даргаас Сангийн яаманд өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлого,төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, ОНӨГ зэрэг шалгагдагч болон хамрагдагч этгээдээс ирүүлсэн холбогдох баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ
Аудитын арга зүй	Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитад АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. - Төрийн Аудитын тухай хууль - Төсвийн тухай хууль - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, - Төрийн хэмнэлтийн тухай хууль - Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль - Монгол Улсын Ерөнхий аудиторов А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” - Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” - Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” - Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, Д.Эрдэнэцэцэг, Б.Бадрал аудитор Д.Мөнхтулга, А.Нарандэлгэр, Н.Ариунтуяа нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 11 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 25-ыг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1¹-д заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, хөрөнгө оруулалтын жагсаалт нь хэд хэдэн удаа өөрчлөгдсөн нь аймгийн ИТХ-д хуульд заасан хугацаанд төсвийг дүгнэлт гаргахад хүндрэлтэй байлаа.

¹ аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх




ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь "...аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу Ховд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж, дүгнэлт гаргав.

Ховд аймгийн ТЕЗ-ын 2025 оны төсвийн орлогыг нийт дүнгээрээ 131,900.4 сая төгрөгөөр төлөвлөсний 44 хувь буюу 58,734.3 сая төгрөгийг татварын, 2 хувь буюу 2,604.0 сая төгрөгийг татварын бус орлогоор, 12 хувь 16,499.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 11 хувь буюу 14,027.6 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр, 23 хувь буюу 30,475.8 сая төгрөгийг ОНХС-ийн орлогын шилжүүлгээр, 7 хувь буюу 9,000.0 сая төгрөгийг Хөшөөт хөгжил сангаас, 1 хувь буюу 510.0 сая төгрөгийг бусад эх үүсвэрээр бүрдүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн суурь орлогыг 57,734.5 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас цалин, эрчим хүчний нэмэгдэлтэй холбогдуулан 71,762.0 сая төгрөгөөр, ОНХС-гийн орлогын шилжүүлгийг 30,475.8, нийт 102,237.8 сая төгрөгөөр хянан ирүүлсэн байна.



Орон нутгийн 2025 оны төсвийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн дагуу аймгийн ТЕЗ нь Сангийн яамнаас хянасан орлогыг 29,662.9 сая төгрөгийн нэмэгдүүлсэн байна. Үүнд: Урьд оны үлдэгдлээс 16,499.1 сая, Хөшөөт хөгжил сангаас 9,000.0 сая, замын сан, техник хяналтын зардал, авлага барагдуулалтаас 510.0 сая, татварын орлогыг (цалингийн орлого 1,425.2, улсын тэмдэгтийн хураамж 1,201.0, үл хөдлөх хөрөнгийн татвар 212.0) 2,838.2 сая төгрөг, татварын бус орлогыг 1,015.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, ан амьтан агнах зөвшөөрлийн хураамжийг 200.0 сая төгрөгөөр бууруулан аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Орон нутгийн 2025 оны нийт зарлага 131,900.4 сая төгрөг байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2,250.3 сая төгрөгөөр буурч төлөвлөгдсөн нь урсгал зардлыг бууруулсантай холбоотой байна.



**БҮЛЭГ 1. ОРЛОГЫГ 129.7 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, ТАТВАРЫН БУС
ОРЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

Татварын орлогыг 109.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна

1.1 Ховд аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулсан байна.

1.2 Харин аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй байгаа тул 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан эсэхийг дүгнэх боломжгүй, Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын 2025 оны төсөвт хориг тавьсан тул улсын төсвөөс санхүүжих хөтөлбөр, төсөл арга хэмжээг тусгаагүй болно.

1.3 Татварын орлогыг 2023 оны гүйцэтгэлээс 10,132.4 сая, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 10,087.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн 58,734.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.4 2025 оны төсвийн төсөлд цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татварын орлогыг сангийн яамнаас 25,405.0 сая төгрөгөөр хянан баталгаажуулснаас төрийн албан хаагчдын цалинг 2025 оны 1 сараас 6 хувиар нэмэгдэх тул 1,195.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 26,600.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.5 Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус баталж импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар хөнгөлөхөөр тусгасан байхад аж ахуй нэгжийн орлогын албан татварыг 2025 онд 20,350.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 7,350.0 сая төгрөгийн нэмэгдүүлсэн нь орлого биелэхгүй, эрсдэл үүсэж болзошгүй байна.

1.6 Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн төсөлд газрын төлбөрийн орлогыг 1,928.0 сая төгрөгөөр Сангийн яамнаас хянуулан төлөвлөсөн нь Засгийн газраас тогтоосон газрын суурь үнэлгээ, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон итгэлцүүр, эзэмшил, ашиглалтад байгаа газрын мэдээлэл болон ирэх онд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний нөлөөлөл, 2024 оны газрын төлбөрийн ногдол, урьд оны өр, авлага зэрэгт үндэслэсэн байна.

1.7 Мянгад сумын газрын төлбөрийн орлогыг 2024 онд 18.9 сая төгрөгөөр төлөвлөн баталсан, 2025 онд 653.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн буудлын зориулалтаар эзэмших 3,028.2 га газрын төлбөрийн орлогод цахим мэдээллийн санд 925.7 сая төгрөгийн төлбөрийн ногдуулалт үүсгэсэн нь 290.7 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн ч тухайн байгууллагын төсөвт газрын төлбөрийг төлөвлөн батлуулаагүйгээс орлогын төлөвлөгөө тасрах эрсдэлтэй байна.

1.8 Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 5/08 дугаар тогтоолын хавсралтын дагуу аймгийн нутаг дэвсгэрт олон улсын чанартай, орон нутгийн чанартай, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зам, мэдээлэл холбооны шугам сүлжээ, эрчим хүчний шугам сүлжээ, дулаан цэвэр бохир усны шугам сүлжээний газрын төлбөрийн итгэлцүүрээр ногдуулалт хийгдээгүй,



тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаагүй тул тогтоолын хэрэгжилтээр газрын төлбөрийн орлогоос 21.2 сая төгрөг төсөвт төвлөрүүлэх боломжтой байна. (Хавсралт №1)

1.9 Хог хаягдлын хураамжийн тухай хуулийн 9.2.2²-д заасны дагуу сумдын ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын хураамжийн орлогыг айл, өрх, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүрээр сар, жилээр тооцон орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан.

1.10 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2025 оны төсвийн төсөлд 80.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсан ч сумуудын ИТХ-аар баталж, Хууль зүй дотоод хэргийн яамаар хянуулсан тогтоолтой хог хаягдлын үйлчилгээний хураамжийн бодитой тоо мэдээлэлд үндэслээгүй, батлагдсан тарифтай уялдуулан төлөвлөөгүйгээс 66.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж байна. (Хавсралт №2)

1.11 Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.27³ дахь заалт, 31⁴ дүгээр зүйлд заасны дагуу мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн тоо мэдээ судалгаанд үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг тооцоходоо Мөнххайрхан, Дарви, Дуут, Цэцэг, Зэрэг, Дөргөн сумдад дулаан хангамжийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс ус ашигласны төлбөрийг тооцож төлөвлөж, орлого бүрдүүлдэггүй, Аймгийн БОАЖГ, Үенч Бодонч Булган сав газрын захиргаанаас дулаан хангамж, хайгуул, тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниад ус ашиглуулсны төлбөрт ноогдуулсан 22.3 сая төгрөгийн орлогыг төлөвлөөгүй байна. (Хавсралт №03,04)

Татварын бус орлогыг төлөвлөлтийг оновчтой болгон төлөвлөх шаардлагатай байна.

1.12 ТӨБЗГ-ын 2020 оны 49 тоот тогтоолын хавсралтаар “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ын 1⁵-д зааснаар орон нутгийн өмч хөрөнгийг бусдад түрээслүүж, түрээсийн гэрээ байгуулснаас орлого бүрдүүлэх боломжтой.

1.13 Аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй орон сууцыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 127 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “албаны орон сууц эзэмшүүлэх журам”-ын 3.1⁶ дэх хэсэгт зааснаас бусад хувь хүмүүст ашиглуулж байгаа өмнөх оны аудитаар өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй, ТӨБЗГ-ын 49 тоот тогтоолын жишиг үнэ, зах зээлийн түрээсийн үнэлгээгээ тооцоход 20.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжтой. Хүснэгт 1. Аймгийн ЗДТГ-ын эзэмшлийн байрны судалгаа

д/д	Орон сууцны нэр	Өрөөний тоо	Хэмжээ М2	Жишиг үнэ (төгрөг)	Нийт үнэ	жилийн нийт дүн
1	Домбот хотхоны 2 дугаар 48 айл	3	68.21	5,000	341.1	4,092.6
2	2 дугаар 80 айл	2	30	5,000	150	1,800.0
3	3 дугаар 36 айл	2	24.4	5,000	122	1,464.0
4	Даатгалын 12 айл	2	32.6	5,000	163	1,956.0
5	ЭСБА-гийн 80 айл	2	45.7	5,000	228.5	2,742.0
6	ЭСБА-гийн 80 айл	1	36.7	5,000	183.5	2,202.0

² энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох

³ 3.1.27."ус ашиглагч" гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

⁴ 31 дүгээр зүйл.Ус ашигласны төлбөр

⁵ Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэл буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно

⁶ Орон сууцыг дараах байдлаар албан тушаалаар нь байгууллагуудад хуваариалан эзэмшүүлнэ



Нийт	1,188.10	14,256.6
------	----------	----------

1.14 Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн хөрөнгөөр сумдын ЗДТГ-д бүртгэгдсэн ковш, хогны машин бүртгэлд авч гэрээгээр ашиглуулж байгаа, Аймгийн ЗДТГ-т Бугат багт баригдсан заал эзэмшиж байгаа ч өөрийн орлогыг төлөвлөөгүй, сумуудад 0.6 сая төгрөгийг орлого тооцоогүйгээр төсөвлөсөн байна.

1.15 Мөн сумдын ЗДТГ дансанд бүртгэлтэй уурын зуухны барилгыг дулаан хангагч байгууллагад ашиглуулан Чандмань сум түрээсийн гэрээ байгуулсан ч орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, Эрдэнэбүрэн, Дуут, Дөргөн, Мянгад сумдууд гэрээ байгуулаагүй ашиглуулж байна.

1.16 Гэтэл тухайн хөрөнгүүдийг анх төсөвт тусгаж бэлтгэхдээ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг хэрхэн шийдвэрлэхийг тооцоогүй, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх судалгаа дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгээд байна.

1.17 Сумдын удирдлагуудаас тухайн суманд бүртгэлтэй техник хэрэгслийг суманд хариуцан ажиллуулах хүнгүй, эвдэрсэн тохиолдолд сэлбэг хэрэгсэл авах төсөв, санхүүгүй, түрээслэх эрх зүйн зохицуулалт, зөвлөмж чиглэл тодорхойгүй, сум, орон нутагт байнга ашиглах боломжгүй, хүйтний улиралд байлгах граж байхгүй, ихэнхдээ айлын хашаанд хадгалагдах байдалтай, зарим нь жилд цөөхөн ашигладаг, зарим нь одоо болтол бичиг баримтгүй гэх мэт асуудлууд тулгарч байна.

1.18 Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй”, 2.1-д “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, 2.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх”, 78 дугаар зүйлийн 2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 2.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах” гэж заасан эрхийн хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирч, төсвийн үр ашиг нэмэгдэх боломжтой байна.



БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДЭХ АЖЛУУДЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Урсгал зардлыг тооцоо судалгаанд үндэслэн нэмэгдүүлэн төлөвлөсөн байна

2.1 Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 65,509,5 сая төгрөг, 51 төсвийн байгууллага, 736 төрийн албан хаагч байхаар Сангийн яам зардлыг хянасан байна.

2.2 Орон нутгийн төсвийн нийт зардалд 131,900,4 сая төгрөг төлөвлөсний 51.3 хувь буюу 65,509,5 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын урсгал зардалд, 48. хувь буюу 66,390.9 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын зардалд, хуваарилсан байна.

2.3 Цалин хөлс нэмэгдэл урамшуулалд 26,007.4 сая төгрөг төлөвлөж 5,796.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь 2025 онд төрийн албан хаагчдын цалинг 6 хувиар нэмэгдүүлсэн, мөн Засаг даргын дэргэдэх агентлагууд болон орон нутгийн төсвийн байгууллагуудын улс төрийн болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 10 хувиар бодож тооцсон нь нөлөөлжээ.

2.4 Шинээр ашиглалтад орж байгаа спорт заал, цэцэрлэг, сургуулийн тогтмол зардалд 2,703.8 сая төгрөг, БОЭТ-ын байр ашиглалтын тогтмол зардалд 2,425.1 сая төгрөг, ашиглалтад ороод үйл ажиллагаа явуулж байгаа Булган, Манхан сумдын Спорт цогцолборын үйл ажиллагааны зардалд 746.3 сая төгрөгийг, Зэрэг, Мөнххайрхан, Мөст, Эрдэнэбүрэн сумдын спортын заалны үйл ажиллагааг хариуцах дасгалжуулагч болон үйлчлэгчийн цалингийн зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилсан байна.

2.5 Аймгийн ИТХ-аас баталсан “Авто зам, замын байгууламж ашигласны төлбөр”- ийн журмын дагуу 204.0 сая төгрөгийг төвлөрүүлэн чиг үүргийг сумдад олгож санхүүжүүлэн зарцуулахаар тусгасан байна.

2.6 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврээр зорчиход олгон нийтийн тээврийн унааны хөнгөлөлтөд 60.0 сая төгрөгийг, хүүхдийн автобусны зардалд 103.4 сая төгрөгийг тусгаж Жаргалант сумын төсөвт, Засгийн газрын 2012 оны 209 дүгээр тогтоолын дагуу гэр хорооллын айл өрхөд усны үнийн хөнгөлөлт үзүүлэхэд зориулан 55.3 сая төгрөгийг тусгасан байна.

2.7 Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 4⁷-т заасны дагуу харьяа байгууллагуудын бүтэц, орон тооны хязгаарыг тулган баталгаажуулахад аймгийн Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагууд Сангийн яамны хянасан тооноос 13 орон тоогоор илүү орон тоогоор ажилласан тул орон тооны төлөвлөлтийг оновчтой болгох шаардлагатай байна.

Хүснэгт-2		Засаг даргын эрхлэх хүрээний бүтэц орон тоо				
Төсөвт байгууллага	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	2025 оны орон тооны санал	2025 оны Сангийн яам хянасан орон тоо	Орон тооны зөрүү /илүү/	Цалингийн зөрүү /сая.төг/
Худалдан авах ажиллагаа	11	11	11	7	4	58.1
Орон нутгийн өмчийн газар	11	12	12	7	5	72.6
Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	11	11	11	7	4	63.3
Нийт албан хаагч	33	34	34	21	13	194.0

Тайлбар: Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагч нарын үндсэн цалингаар цалингийн тооцоолол хийсэн

⁷ Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан агентлаг ажиллуулахаар тогтоосугай:



Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй, ерөнхий нэрээр тусгасан төсөл арга хэмжээнүүд нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахгүй байна

2.8 Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 9,915.9 сая, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 29,532.0 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 2,585.5 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барилга, байгууламжийн их засварын зардалд 6,511.5 сая төгрөг, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд 1,096.3 сая төгрөгийг, нийт 49,641.2 сая төгрөгийг 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна

2.9 Орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтад 12,271.4 сая төгрөгийн өртөг бүхий 11,931.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 35 төсөл арга хэмжээний тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг тусгасан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3⁹ дах заалтуудыг зөрчиж байна. **Хавсралт №5**

2.10 Аймгийн 2025 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан 5,238.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжүүлэх 24 төсөл арга хэмжээг олон нийтээр хэлэлцүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 29.2.6¹⁰ -дахь заалттай нийцээгүй тул цаашид олон нийтээр хэлэлцүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

2.11 Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад 543.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй, ямар ажил хэрэгжүүлэх нь тодорхойгүй, өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг дахин төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1¹¹ -д заасантай нийцээгүй тул иргэдийн санал авч дэмжигдсэн төсөл арга хэмжээг төлөвлөх.

Хүснэгт-3: Төсөвлөлтийн шаардлагад шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээ

Данс	№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
ОНХО	4.10	Барилгын дотор засварын ажил (ЗДТГ)	2025	200.0	200.0
ОНХО	3.4	Авто машин (ШШГГ)	2025	30.0	30.0
ОНХО	3.7	Эсба байрны засвар, тохижилт (Цамбагарав баг,лифт)	2025	110.0	110.0
ОНХС	4.4	Нөөцийн агуулахын засварын ажил (ЗДТГ)	2025	153.7	153.7
ОНХС	4.20	Өөлдийн хорооллын зам засварын ажлын буулгалтын зардал	2025	50.0	50.0
Нийт дүн				543.7	543.7

2.12 Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх жагсаалтад төлөвлөсөн 2,771.2 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээ нь өмнөх онд төсвийн

⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁹ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

¹⁰ олон нийтээр хэлэлцүүлсэн байх

¹¹ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна



тодотголоор нэмэгдсэн ч тайлант онд хэрэгжүүлээгүй нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4¹² дахь заалттай нийцээгүй. Хавсралт №6

2.13 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилгыг улсын комисс зураг төсвийн дагуу хүлээн аваагүйгээс 2025 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар Эсба байрны лифт суурилуулах ажилд 110.0 сая төгрөг төлөвлөсөн нь төсвийн үр ашгийг бууруулсан байна

2.14 Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй 5,500.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹³ дахь заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт-4: Ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй ТАХ-ний жагсаалт

Данс	№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	2025 онд санхүүжүүлэх дүн
ОНХС	2.3	Хог хаягдлын менежментийг сайжруулах (Техник, тоног төхөөрөмж)	2025	2,000.0
ОНХС	2.4	Ногоон байгууламж, бүтээн байгуулалт, тохижилт	2025	1,500.0
ОНХО	5.1	Баялаг бүтээгчдийг дэмжих, бизнесийн орчин бүрдүүлэх арга хэмжээний зардлын санхүүжилт	2025	2,000.0
Нийт дүн				5,500.0

2.15 Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад хэрэгжүүлэхээр тусгасан төсөл арга хэмжээний санхүүжих дүнг хянасан төсвөөс зөрүүтэй тусгасан байна.

Хүснэгт 5 Төсөв зөрүүтэй ТАХ-ний жагсаалт

Данс	№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн	Хянасан төсөв
ОНХО	2.2.	Цэвэр усны хангамжийг сайжруулах (Дөргөн сум)	2025	230.0	230.0	298.20
ОНХО	6.24	Барилгын сан техникийн засвар (Хөгжил политехник коллеж)	2024-2025	48.6	48.6	89.90
ОНХС	2.23	Байрны засвар (Хангамжийн 28 айл)	2025	100.0	100.0	123.5
ОНХС	4.7	Дулаан, цэвэр бохирын шугам (Цамбагарав баг)	2025	90.0	90.0	49.2
ЗС	1.1	Авто замын засвар, шинэчлэлт (Ховд аймаг, Жаргалант сум)	2025	2,071.00	2,071.00	1,498.80
ИЗ	2.5	ЕБС-ийн засвар (Жаргалант сум, 3-р сургууль)	2025	650.0	650.0	1,442.70
ИЗ	2.17	Биеийн тамирын талбайн засвар, тохижилт Мянгад сум	2025	150.00	150.00	130.00
Нийт дүн				3,339.6	3,339.6	3,632.3

¹² төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

¹³ санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах



БҮЛЭГ 3. ОНХС-ГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ, ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭН АВЛАГЫГ БУУРУУЛСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Төсвийн төсөлд 18 хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээг төлөвлөжээ

3.1 2025 оны төсвийн төсөл боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлд Төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, төсвийн орлогын бааз суурийг тэлэх, татварын орлогыг нэмэгдүүлэх, хуримтлагдсан татварын өр төлбөрийг барагдуулах анхаарах чиглэлийг баталсан байна.

3.2 Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Бүсчилсэн хөгжлийн татварын бодлогыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоол батлагдаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох татварын хувь хэмжээг бүсийн тэргүүлэх чиглэл, нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэн тогтоож, 2025 оны төсвийн жилээс мөрдөхөөр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

3.3 Ховд аймагт 15 нэр төрлийн 1,479.8 сая төгрөгийн хуримтлагдсан татварын өр байгаагаас харахад орон нутгаас татварын өр барагдуулалтад дэмжлэг үзүүлэх, улсын төсвийн санхүүжилтээс татварын өрөнд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

3.4 Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2-т “хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх,” 31.4.6-д “төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо” гэсэн заалтын дагуу ТЭЗ-ийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг төлөвлөх ёстой.

3.5 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг цахим системд (<https://bps.mof.gov.mn/>) боловсруулж, тайлагнан хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг цахимжуулах ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, эхсэл тооцооллоор хийсэн тайлагналаас үзэхэд 18 хөтөлбөрийн хүрээнд төлөвлөжээ.

3.6 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасны дагуу орон нутгийн 2025 оны төсвийн төслийг Сангийн ямаар хянуулахаар хүргүүлсэн төсөвт өрийн бичиг, бонд, зээлтэй холбоотой авлага, өглөг үүсгээгүй нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.7 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2-т заасны дагуу 60 хувийг сумын ОНХС-д хуваарилаагүйгээс аймгийн ОНХС –д 3,570.0 сая төгрөгийг илүү, сумуудад Алтай, Булган, Буянт, Дарви, Мянгад, Дөргөн, Үенч сумдад дутуу хуваарилж байгаа нь ашигт малтмал, газрын тосны ашиглалтын орлого олсон нутаг дэвсгэрт хуваарилах зарчимд нийцэхгүй байна.

3.8 Ховд аймагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ч орон нутгаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтад тавих хяналт хангалтгүйгээс тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу түгээмэл ашигт малтмалын төлбөрийг ногдуулаагүй, төсвийн орлого олох боломжоо алдаж байна.

3.9 Тоосгоны үйлдвэрлэл, хайрга дайрга ашиглалтын карьер, зам барилгын ажилд ашигласан элс, хайрганы хэмжээг нарийн тодорхой тогтоогоогүй, олборлолт хийсэн газарт хэмжилт хийгдээгүй зэрэг шалтгаанаас үүдэн ашиглалтын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид ногдуулах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр хураамжийн ногдуулалт харилцан адилгүй, бүрдүүлэлт хангалтгүй байна.



	Талбайн нэр	Төрөл	Эзэмшигч	Олгосон	Дуусах	Талбай
1	Бугат	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Соёмбот шүтээн хайрхан	2024.06.24	2027.06.24	25.05
2	Хатуу хөтөл	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Нью минерал	2024.07.02	2027.07.02	26.16
3	Хатуу хөтөл	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Жигд-Өргөө	2024.05.06	2027.05.06	39.28
4	Элст	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Вестерн холд	2023.11.13	2038.11.13	240.01
5	Улаан хавчиг	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Буянт стандарт	2023.12.11	2038.12.11	42.52
6	Хондлойн ар	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Торгор трейд	2023.04.01	2026.04.01	25.78
7	Цагаан шал	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Тунгалаг буянт	2023.10.13	2026.10.13	27.15
8	Адаг усны эх хавцал	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Буянт стандарт	2023.12.27	2026.12.27	25.51
9	Бугат хайрга	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Ховдын тулга	2023.01.18	2026.01.18	25.06
10	Хайргат	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Жаргалант буд трейд	2023.01.18	2026.01.18	39.43
ДҮН						515.95

3.10 Иймд Аймгийн БОАЖГ, ГХБХБГ, Татварын хэлтэс, ХОХБХ мэргэжилтэн, худалдан авах ажиллагааны газар зэрэг төрийн байгууллагууд ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаагаа сайжруулж түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг бүрэн хийх, хууль бус үйл ажиллагаанд зохицуулалт хийх, орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.11 2025 оны төсвийн төсөлд улсын тэмдэгтийн хураамжийн орлогод Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх үйлчилгээний орлого 1,000.0 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.9 дэх заалтад дээрх орлого нь улсын төсвийн татварын орлого байхаар заасантай нийцэхгүй байх тул уг орлого биелэхгүй байх эрсдэлтэй байна.

3.12 2020-2023 онуудад хийж хэрэгжүүлсэн 122 ТАХ-ний 11,177.3 сая төгрөгийн ажлуудыг одоог хүртэл хүлээлгэн өгөөгүй, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын өгөөжийг иргэд, олон нийт хүртэхгүй байгаа тул нэн тэргүүнд дуусгаж ашиглалтад оруулах, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт №7 ТЕЗ-ийн 2023 оны авлагын үлдэгдлийн судалгаа

д/д	Эх үүсвэрийн зориулалт	Аж ахуй нэгж байгууллагын тоо	Мөнгөн дүн (сая.төг)
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	4	450.24
2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	15	1,201.83
3	Орон нутгийн хөгжлийн сан	29	4,789.40
4	Хөшөөт хөгжлийн сан	3	95.67
5	Ховд хөгжлийн сан	56	936.08
6	Засаг дарга	7	504
7	Барьцаа	7	1,948
8	Орон нутгийн ерөнхий орлого	1	1,251.53
Нийт дүн		122	11,177.31

Эх сурвалж нь: Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан



3.13 Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал 213.0 сая, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээний зардал 472.6 сая, нийт 685.6 сая төгрөг Байгаль хамгаалах сангийн жагсаалтад 300.0 сая, ОНХС-ийн 2.4 -д 1,500.0 сая баталж байгааг дахин хуваарилах боломжтой байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна

3.14 Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

3.15 Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

3.16 Аймгийн ТЭЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар аймгийн ИТХ, Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт 4 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 32.5 хувьтай байгаа нь зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 8. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

	зөвлөмжийн утга	хэрэгжилт	хувь
Аймгийн ИТХ-д	БХС, ОНХС, ОНХО, Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29, 291 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөн батлах	Орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх хөрөнгө оруулалтаар 35 төсөл арга хэмжээг зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй тусгасан нь зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	30%
Аймгийн Засаг даргад	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасан хугацаанд төсвийн төслийг боловсруулан, өргөн барих	Аймгийн 2025 оны төсвийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 1/2111 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.	100%
	Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно" гэсэн заалтыг хэрэгжүүлэн айл өрхийн хог хаягдлын хураамжийг нэгдсэн байдлаар төвлөрүүлэх	Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.	0%
Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад	Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасны дагуу Булган сумын хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	Аймгийн СТСХ-ээс 2024 оны 5/284 дугаартай албан бичгээр хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх талаар хүргүүлсэн ч 2025 оны төсөвт бодитой төлөвлөж батлуулаагүй	0%
Зөвлөмжийн хэрэгжилт дундаж хувь			32.5%



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

- Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 129.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, 9,171.5 сая төгрөгийн зардлыг оновчтой төлөвлөж төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлэх санал, дүгнэлтийг хүргүүлж байна.
- Аймгийн 2025 оны төсвийн төсөлд ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үндсэн хөрөнгө ашиглалттай холбоотой зардлын тооцооллыг ирүүлээгүй нь төсвийн зорилго хангагдсан эсэхийг үнэлэх боломжгүй Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчсөн байна.
- Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, түрээслүүлэх замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2-т заасны дагуу 60 хувийг сумын ОНХС-д хуваарилаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан шаардлага хангасан төсөл арга хэмжээг батлах
2. Засгийн газрын 2024 оны “Бүсчилсэн хөгжлийн татварын бодлогыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоолын дагуу бүсийн тэргүүлэх чиглэл, нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэн татварын хувь хэмжээг тогтоох

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

1. Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29, 29.1¹⁴ дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹⁵-д заасан төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх
2. Төсвийн төсөлд төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол болон хөрөнгийн ашиглалттай холбоотой тооцооллууд, нотлох баримтаар баталгаажсан холбогдох баримт бичгүүдийг иж бүрэн ирүүлж байх
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2-т заасны дагуу хуваарилах

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэх

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

¹⁴ 29.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

¹⁵ 13.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:

**ХАВСРАЛТУУД**

Хавсралт №01

Зам, шугам сүлжээний газрын төлбөр ногдуулаагүй/ мян.төг/

д/д	Төсөл хэрэгжүүлж буй аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч	Хэмжих нэгж /км/	Газрын төлбөр
1	Ховд аймаг, бүх сумдад	мэдээлэл холбооны шугам сүлжээ	Моби ком	506	3,795.00
2	Ховд,Жаргалант сум		Мэдээлэл холбооны сүлжээ	1,187	8,902.50
3	Ховд,Жаргалант сум, бүх сумдад	эрчим хүчний шугам сүлжээ	Цахилгаан түгээх сүлжээ	100	750
4	Ховд,Жаргалант сум, бүх сумдад		Баруун бүсийн эрчим хүч	546	4,095.00
5	Ховд аймаг Дарви, Цэцэг, Алтай, Үенч, Булган сум	олон улсын чанартай зам	Мон эн ко ххк	311	2,332.50
6	Цэцэг сум	дотоод зам	Мон эн ко ххк	45	337.5
7	Шим Ус ОНӨААТҮГ		Шим Ус ОНӨААТҮГ	69	517.5
8	Ховд, Жаргалант сум		Ховд Шинэ дулаан ХХК	18.3	137.3
9	Ховд,Жаргалант сум		Бадамлах дөл ХХК	14.2	106.5
10	Ховд. Алтай сум		Тоосгон уул ХХК	1.4	10.5
11	Ховд. Булган сум		Булган түшиг ХХК	4.81	36.1
	Ховд. Буянт сум		Жаргалант буд трейд ХХК	1.2	9
12	Ховд. Дарви сум		Энержи Импайр ХХК	1.7	12.8
13	Ховд, Дуут сум		Эрдэс тайга ХХК	1.4	10.5
14	Ховд, Дөргөн сум	Дулааны, цэвэр бохир усны шугам	Жигүүр Ажнай ХХК	0.94	7.1
15	Ховд, Зэрэг		Тээлийн илч ХХК	1.8	13.5
16	Ховд, Манхан		Эрчим дөл ХХК	1.4	10.5
17	Ховд, Мөнххайрхан		Солонготалст ХХК	1.4	10.5
18	Ховд, Мянгад сум		Тоосгон уул ХХК	1.4	10.5
19	Ховд, Ховд сум		Вива зоне ХХК	1.4	10.5
20	Ховд, Чандмань сум		Эрдэс тайга ХХК	2.09	15.7
21	Ховд, Цэцэг сум		Эрчим дөл ХХК	2.16	16.2
22	Ховд. Үенч сум		Мирай кэнсэнцү ХХК	1.7	12.8
23	Ховд, Эрдэнэбүрэн		Вива зоне ХХК	1	7.5
НИЙТ ДҮН				2,821.90	21,164.30



Хавсралт №2 ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ТООЦОО

Table with 18 columns: Д/д, Сум, дүүргийн нэр, сумын төвийн өрхийн тоо, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, төг, ААН, байгууллага, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, төг, төсөвт байгууллага, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, төг, Үйлдвэрлэл, уйлчилгээний газар, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, төг, ШТСтанц, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, мян.төг, эмийн сан, банк, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, худалдаа эрхлэгч, Сарын төлбөр, төг, Нийт төлбөр, төг, Нийт дүн, төг.

Хавсралт №03 Үенч-бодонч-булган голын сав газрын захиргааны 2024 онд ус ашиглуулах дүгнэлтийн судалгаа

Table with 7 columns: №, Иргэн, ААН, байгууллагын нэр, Үйл ажиллагааны чиглэл, Төслийн байршил, Дүгнэлт гаргасан огноо, Ашигласан усны хэмжээ, м.куб, Ноогдуулсан төлбөр,төгрөг.



Хавсралт №04 Ус ашиглагч тээврийн компаниудын судалгаа

д/д	Компаний нэр	Машины тоо	Худгийн мэдээлэл	Тоолуур суурилуулсан хугацаа	Тоолуурын заалт		Ашиглах усны хэмжээ /метр.куб/	1 м3 усны үнэ	Усны төлбөр /төгрөг/
					огноо	заалт			
1	"Мянганцогт" ХХК	8					195.4	188.16	36,766
2	"Мянган орд" ХХК	43	1	8	11/15/2024	954	1802.8	188.16	339,214
3	"Алтайн даваа" ХХК	50	1		11/15/2024	533	1520	188.16	286,003
4	"Баруун бэйс" ХХК	36					879.4	188.16	165,467
5	"Цаст Алтайн жинчид" ХХК	50	1	8	11/15/2024	244	1231	188.16	231,624
6	"Мөнх төгрөгийн гол" ХХК	47	1	8	11/15/2024	533	1460.7	188.16	274,845
7	"Хар нүх" ХХК	50	1	5	11/15/2024	283	1056.5	188.16	198,791
8	"МС Мандуул" ХХК	25					610.7	188.16	114,909
9	"Торгон транс" ХХК	40	1	8	11/15/2024	665	1454.6	188.16	273,697
10	"Бадрах буд" ХХК	28	1				684	188.16	128,701
11	"Хулман транс" ХХК	45	1	5	11/15/2024	811	811	188.16	152,597
12	"Баянголын хүлгүүд" ХХК	62	1	8	11/15/2024	974	2,197.8	188.16	413,538
13	"Алтай строй" ХХК	40	1	8	11/15/2024	667	1,456.6	188.16	274,073
14	"Цаст тээлийн зам" ХХК								
15	"Баатрын жинчид транс" ХХК	26	1	8	11/15/2024	793	1306.2	188.16	245,774
16	"Үенчийн хүлгүүд" ХХК	48	1	5	11/15/2024	642	1384.5	188.16	260,507
17	"Саша ням" ХХК	33	1	8	11/15/2024	617	1169.7	188.16	220,090
18	"Тэнүүн жинчид" ХХК	22	1	8	11/15/2024	285	719.2	188.16	135,324
19	"Мөнх таван эрдэнэ" ХХК	37	1				903.8	188.16	170,059
20	"Апарт рөүд" ХХК	26					635.1	188.16	119,500
21	"Мөст цэвэрлэгэ булаг" ХХК	43	1	5	11/15/2024	760	1425.1	188.16	268,146
22	"Булган хөрс" ХХК	41	1				1001.5	188.16	188,442
23	"Бадамлах хөшөөт" ХХК	28	1				684	188.16	128,701
24	"Эх газрын жинчид" ХХК	28	1	5	11/15/2024	1792	2225.1	188.16	337,182
25	"Хас баян трэйд" ХХК	8	1	8	11/15/2024	441	598.9	188.16	112,689
26	"Мандал хишиг" ХХК	25	1				610.7	188.16	114,909
27	"Төр бум" ХХК	25	1				610.7	188.16	114,909
28	"Бадамлах жинчид" ХХК	28					684	188.16	128,701
29	"Булган гол" ХХК	52					1270.3	188.16	239,019



30	"Буянт Алтайн билэг" ХХК	22	537.4	188.16	101,117
31	"Интернэйшнл рөүд" ХХК	30	732.9	188.16	137,902
32	"Мину Эйс транс" ХХК	30	732.9	188.16	137,902
33	"Мөнгөн хүлэг трейд" ХХК	10	244.3	188.16	45,967
34	"Тэнгэрлэг нутаг" ХХК	20	488.6	188.16	91,934
35	"Шонхорын хүлэг" ХХК	30	732.9	188.16	137,902
36	"Эм И Си транс" ХХК	39	952.7	188.16	179,260
37	"Этуна сүлд транс" ХХК	8	195.4	188.16	36,766
НИЙТ ДҮН					6,542,927



Хавсралт №5 Зураг төсөв, урьдчилан тооцоолол байхгүй төсөл арга хэмжээний судалгаа /сая.төг/

Данс	№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
ОНХО	2.1	Худаг гаргах 2ш (ШШГГ)	2025	80.0	80.0
ОНХО	3.1	Авто машин парк шинэчлэл (ИТХ, ЗДТГ)	2025	600.0	600.0
ОНХО	3.3	Албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж- СХАА	2025	30.0	30.0
ОНХО	3.5	Усны машин (Дарви сум)	2025	80.0	80.0
ОНХО	3.6	Сургалтын тоног төхөөрөмж (Бугат ӨЭМТ)	2025	30.0	30.0
ОНХО	3.8	Хөргүүртэй контейнер (Цэцэг сум)	2025	150.0	150.0
ОНХО	3.10	Авто машин (Гадаадын иргэн харьяатын газар)	2025	300.0	300.0
ОНХО	4.2	Шинэ суурьшлын бүсийн 8ш холбооны худаг шинэчлэх	2025	30.4	30.4
ОНХО	4.3	Жаргалан сумын 7-р сургуулийн уулзварын кабель шинэчлэх	2025	45.0	45.0
ОНХС	2.2	Авто замын засвар, шинэчлэлт (Ховд аймаг, Жаргалант сум)	2025	2,429.0	2,429.0
ОНХС	2.3	Хог хаягдлын менежментийг сайжруулах (Техник, тоног төхөөрөмж)	2025	2,000.0	2,000.0
ОНХС	2.4	Ногоон байгууламж, бүтээн байгуулалт, тохижилт	2025	1,500.0	1,500.0
ОНХС	2.5	Гудамж төсөл (Жаргалан сум Наран, Рашаант баг)	2025	1,000.0	1,000.0
ОНХС	2.7	"Ховд ВОХ" гадна шугам сүлжээний ажил	2025	200.0	200.0
ОНХС	2.10	Соёл амралтын хүрээлэн (Манхан сум)	2025	250.0	250.0
ОНХС	2.11	Гудамжны тохижилт (Жаргалант сум)	2025	200.0	200.0
ОНХС	2.12	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах (Бичигт баг)	2025	100.0	100.0
ОНХС	2.14	Алтайн оргил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт (Үенч сум)	2025	200.0	200.0
ОНХС	2.15	Гудамж талбайн тохижилт (Дуут сум)	2025	100.0	100.0
ОНХС	2.16	Үерийн суваг татах, хашааны хаягжуулалт (Буянт баг)	2025	100.0	100.0
ОНХС	2.18	Дэд бүтцийн зураг төсөв хийх (Хайрхан баг)	2025	100.0	100.0
ОНХС	2.20	Малчны хороололын цахилгааны шугам сүлжээ	2025	200.0	200.0
ОНХС	2.22	Ундны усны эх үүсвэрийг сайжруулах (Алтай сум)	2025	100.0	100.0
ОНХС	4.6	Орон сууцны засвар (Алтайн буйлаастын 30 айл)	2025	200.0	200.0
БХС	1.2	Ногоон байгууламж, бүтээн байгуулалт, тохижилт	2025	300.0	300.0
Их засвар	2.1	Сургуулийн дотуур байрны засвар (Дарви сум)	2025	200.0	200.0
Их засвар	2.3	Цэцэрлэгийн засвар (Дөргөн сум)	2025	350.0	350.0
Их засвар	2.6	Сургуулийн засвар (Жаргалант сум 1-р сургууль)	2025	100.0	100.0
Их засвар	2.8	Сургуулийн дотуур байрны засвар (Алтай сум)	2025	223.0	223.0
Их засвар	2.10	Шугам сүлжээг шинэчлэх (Булган сумын ЕБС-ын 1 сургууль)	2025	250.0	250.0
Их засвар	2.13	Спорт заалны засвар (Жаргалант сум 2-р сургууль)	2025	156.00	156.0
Их засвар	2.14	Эрүүл мэндийн төвийн засвар, тохижилт (Баатархайрхан баг)	2025	200.00	200.00
Их засвар	2.16	Цэцэрлэгийн засвар (Жаргалант сумын 5 дугаар цэцэрлэг)	2025	200.00	200.00
Их засвар	2.18	Бага сургуулийн засвар Мөст сум	2025	269.00	269.00
Их засвар	2.19	Цэцэрлэгийн засвар (Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэг)	2025-2026	679.00	339.50
		Нийт дүн		12,271.4	11,931.9



Хавсралт №6 Урд оны төсвөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт /сая.төг/

Данс	№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
ОНХО	6.1	Цахилгаан шат хийх санхүүжилт (Бүсийн оношилгоо, эмчилгээний төв)	2024-2025	230.4	230.4
ОНХО	6.2	Хэрэглээний халуун усны холболт (Асрамжийн газар)	2024-2025	13.1	13.1
ОНХО	6.3	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлэх (16 дугаар цэцэрлэг)	2024-2025	60.0	60.0
ОНХО	6.4	Хатуу хөтлийн суурин газрын трансформатор барих (Жаргалант сум, Цамбагарав баг)	2024-2025	40.0	40.0
ОНХО	6.5	Хатуу хөтлийн суурин газрын өндөр хүчдэлийн трансформатор (Жаргалант сум, Цамбагарав баг 7-р гудамж)	2024-2025	40.0	40.0
ОНХО	6.9	Баруун бүсийн Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний хүрээлэн ТЭЗҮ боловсруулах (Шинэ Ховд)	2024-2025	150.0	150.0
ОНХО	6.12	Хуучин барилга буулгалтын зардал (БОЭТ)	2024-2025	20.0	20.0
ОНХО	6.15	Авто машин, тавилга, тоног төхөөрөмжийн дэмжлэг (Татварын хэлтэс)	2024-2025	150	150
ОНХО	6.16	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тохируулгатай ширээ сандал (Сургууль, цэцэрлэг бүрт-2ш)	2024-2025	122	122
ОНХО	6.17	Тусгай зориулалтын контейнер худалдан авах дэмжлэг (Шүүх шинэ барилга)	2024-2025	20	20
ОНХО	6.18	Алслагдсан багуудын цахим сүлжээ нэвтрүүлэх туршилт	2024-2025	60	60
ОНХО	6.19	Цахим санхүү, тоног төхөөрөмжийн шинэчлэл	2024-2025	230.0	230.0
ОНХО	6.2	Аймгийн ЗДТГ-ын автомашины шинэчлэл	2024-2025	120	120
ОНХО	6.21	Ус цэвэршүүлэгч төхөөрөмж (Цэцэрлэг 1-16 нэгдэл, 7 сум)	2024-2025	46.0	46.0
ОНХО	6.23	Тохижилт, засвар (1 дүгээр цэцэрлэг)	2024-2025	26.07	26.07
ОНХО	6.24	Барилгын сан техникийн засвар (Хөгжил политехник коллеж)	2024-2025	48.6	48.6
ОНХО	6.27	Хөгжимт драмын театрын урд талбайн тохижилт багц-2	2024-2025	346.0	346.0
ОНХС	6.80	Цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв (Жаргалант сум, Ойн бүс)	2024-2025	150.0	150.0
ЗС	2.2	Ачаа жигнэх пүү (Буянт сум)	2024-2025	160.00	160.00
БХС	3.1	Фургон автомашин (БОАЖГ)	2024-2025	50.0	50.0
БХС	3.2	Байгаль хамгаалагчдын унаа, тоног төхөөрөмж (БОАЖГ)	2024-2025	200.0	200.0
БХС	3.3	Эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт хийх	2024-2025	35.0	35.0
БХС	3.4	Зэгсний гахай, тарвага, саарал чоно, загасны нөөцийн судалгаа	2024-2025	60.0	60.0
БХС	3.6	Говийн гайхамшигт-6 арга хэмжээ зохион байгуулах (БОАЖГ)	2024-2025	20.0	20.0
ИЗ	3.1	Спортын ордны засвар	2024-2025	756.0	288.0
ИЗ	3.2	Дотуур байрны засварын оролцоо Цэцэг сум	2024-2025	86.0	86.0
Нийт дүн				3,239.2	2,771.2